

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ЖАРГАЛАНТ СУМЫН 7 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/ 10/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Ховд хот

2021 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh
@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим хаяг:
Tsetsegsuren.A@audit.gov.mn

Гэрэл Хөхийн тэнцвэр аудит ХХК

Аудитор: Д.Хишгээ

Утас: 99964238 Цахим хаяг: Hishgee.Da@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

АОУС Аудитын Олон Улсын Стандарт

СТА Санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	Error! Bookmark not defined.
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	4
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	7
3. Аудитын тайлан	7
3.1. Ерөнхий зүйл	7
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	8
3.4. Материаллаг байдал	9
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	9
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	13
Аудитын зөвлөмж	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	13
4. Менежментийн захидал	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ. ДҮГНЭЛТ


ХОВД АЙМАГ ДАХЬ ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Б.ТӨГСЖАРГАЛ ТАНАА
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021.02.05 № 2/28
танай _____ -ны № _____ -г


Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын 7 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт
Жаргалант сумын 7 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл
Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.
Аудитаар Жаргалант сумын 7 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.
Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага
Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.
Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР

001000017

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>32 477 987.1</u>	<u>37 047 616.0</u>
33	АВЛАГА	41 544.4	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	41 544.4	-
35	БАРАА МАТЕРИАЛ	32 436 442.7	37 047 616.0
351	Түүхий эд материал	-	685 000.0
35130	Эм боох материал	-	685 000.0
354	Хангамжийн материал	32 021 392.7	35 947 566.0
35410	Бичиг хэргийн материал	112 500.0	80 000.0
35420	Аж ахуйн материал	1 395 000.0	395 000.0
35460	Хүнсний материал	2 421 566.7	789 840.0
35470	Бусад хангамжийн материал	28 092 326.0	34 682 726.0
35500	Биологийн хөрөнгө	415 050.0	415 050.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>515 115 398.9</u>	<u>506 596 583.9</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	515 115 398.9	506 596 583.9
392	Биет хөрөнгө	466 076 198.9	457 557 383.9
39201	Барилга, байгууламж, орон сууц	451 183 537.5	467 182 865.5
39202	Хуримтлагдсан элэгдэл	(22 903 938.2)	(43 060 805.4)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	49 815 246.0	53 864 246.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(32 671 215.5)	(37 070 527.4)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40 614 328.7	40 614 328.7
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21 683 509.6)	(25 694 473.4)
39217	Ном	1 721 750.0	1 721 750.0
393	Биет бус хөрөнгө	49 039 200.0	49 039 200.0
39301	Програм хангамж	200 000.0	200 000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(200 000.0)	(200 000.0)
39303	Бусад биет бус хөрөнгө	49 039 200.0	49 039 200.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>547 593 386.0</u>	<u>543 644 199.9</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>20 772.0</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20 772.0	-
413	Өглөг	20 772.0	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	20 772.0	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>547 572 614.0</u>	<u>543 644 199.9</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	547 572 614.0	543 644 199.9
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	293 284 261.0	293 284 261.0
51101	Өмч: - төрийн	293 284 261.0	293 284 261.0
512	Хуримтлагдсан үр дүн	(109 466 908.2)	(113 395 322.3)
51210	Өмнөх үеийн үр дүн	(109 466 908.2)	(109 466 908.2)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(3 928 414.1)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	363 755 261.2	363 755 261.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>547 593 386.0</u>	<u>543 644 199.9</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>469 668 000.7</u>	<u>550 228 728.0</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>16 856 700.7</u>	<u>20 912 828.0</u>
120	Нийтлэг татварын бус орлого	16 856 700.7	20 912 828.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16 856 700.7	20 912 828.0
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16 856 700.7	20 912 828.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>452 811 300.0</u>	<u>529 315 900.0</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	373 377 500.0	455 585 100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	373 377 500.0	455 585 100.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	70 044 800.0	73 730 800.0

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	70 044 800.0	73 730 800.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	486 576 953.3	554 157 142.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	486 576 953.3	554 157 142.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	486 576 953.3	521 077 648.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	276 856 618.0	353 064 772.0
210101	Үндсэн цалин	207 070 320.0	257 369 303.0
210102	Нэмэгдэл	47 097 744.0	64 750 887.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2 787 100.0
210104	Урамшуулал	22 688 554.0	28 157 482.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35 112 433.4	45 232 449.7
210201	Тэтгэврийн даатгал	23 665 627.4	29 992 420.1
210202	Тэтгэмжийн даатгал	2 765 263.1	3 528 520.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2 212 210.4	2 822 815.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1 007 176.4	2 186 426.7
210205	Эрүүл мэндийн даатгал	5 462 156.1	6 702 267.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66 165 600.0	54 488 357.0
210301	Гэрэл, цахилгаан	4 998 508.0	3 339 911.0
210302	Түлш, халаалт	51 266 364.0	38 046 560.0
210303	Цэвэр, бохир ус	9 900 728.0	13 101 886.0
2104	Хангамж, бараа материалын зардал	843 500.0	663 200.0
210401	Бичиг хэрэг	116 500.0	140 600.0
210402	Тээвэр, шатахуун	61 700.0	61 700.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	175 000.0	115 000.0
210404	Ном, хэвлэл	-	84 000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300 000.0	261 900.0
2105	Нормативт зардал	65 392 836.6	33 093 826.7
210501	Эм, бөлдмөл, эмнэлгийн хэрэгсэл	-	2 727 100.0
210502	Хоол, хүнс	64 732 036.6	28 750 826.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	660 800.0	1 615 900.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7 240 781.0	4 199 500.0
210604	Урсгал засвар	7 240 781.0	4 199 500.0
2107	Томиллолт, зочны зардал	145 600.0	145 600.0
210702	Дотоод албан томиллолт	145 600.0	145 600.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	195 800.0	576 000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	195 800.0	144 000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	432 000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34 623 784.4	29 613 943.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 692 500.0	1 046 800.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32 931 284.4	28 567 143.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	33 079 493.7
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	33 079 493.7
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	33 079 493.7
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(16 908 952.6)	(3 928 414.1)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(16 908 952.6)	(3 928 414.1)

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	453 036 300.0	529 315 900.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	453 036 300.0	529 315 900.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	373 377 500.0	455 585 100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	373 377 500.0	455 585 100.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9 614 000.0	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	250 000.0	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3 364 000.0	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6 000 000.0	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	70 044 800.0	73 730 800.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	70 044 800.0	73 730 800.0

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	493 000 370.0	529 315 900.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	493 000 370.0	529 315 900.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	493 000 370.0	529 315 900.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	277 878 400.0	354 025 700.0
210101	Үндсэн цалин	208 890 100.0	217 494 100.0
210102	Нэмэгдэл	51 876 869.0	109 365 400.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2 787 100.0
210104	Урамшуулал	17 111 431.0	24 379 100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34 110 000.0	47 793 400.0
210201	Тэтгэврийн даатгал	23 194 700.0	33 632 500.0
210202	Тэтгэмжийн даатгал	2 729 000.0	3 540 200.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2 183 100.0	2 832 200.0
210204	Ажилгүйдлийн даатгал	545 700.0	708 000.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5 457 500.0	7 080 500.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66 165 600.0	69 440 500.0
210301	Гэрэл, цахилгаан	4 998 508.0	3 901 800.0
210302	Түлш, халаалт	51 266 364.0	53 076 900.0
210303	Цэвэр, бохир ус	9 900 728.0	12 461 800.0
2104	Хангамж, бараа материалын зардал	985 200.0	654 100.0
210401	Бичиг хэрэг	116 500.0	140 600.0
210402	Тээвэр, шатахуун	111 100.0	61 700.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	325 000.0	115 500.0
210404	Ном, хэвлэл	-	80 300.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	432 600.0	256 000.0
2105	Нормативт зардал	103 656 870.0	50 865 900.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	3 254 300.0
210502	Хоол, хүнс	101 339 990.0	46 518 800.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2 316 880.0	1 092 800.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7 422 400.0	4 290 300.0
210604	Урсгал засвар	7 422 400.0	4 290 300.0
2107	Томилолт, зочны зардал	145 600.0	145 600.0
210702	Дотоод албан томилолт	145 600.0	145 600.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	195 800.0	575 600.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	195 800.0	143 600.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	432 000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2 440 500.0	1 524 800.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2 440 500.0	1 524 800.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(39 964 070.0)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(39 964 070.0)	-

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	293 284 261.00	363 755 261.23	(99 363 352.30)	557 676 169.93
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	293 284 261.00	363 755 261.23	(99 363 352.30)	557 676 169.93
Тайлант үеийн үр дүн	-	-	(10 103 555.89)	(10 103 555.89)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	293 284 261.00	363 755 261.23	(109 466 908.19)	547 572 614.04
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	293 284 261.00	363 755 261.23	(109 466 908.19)	547 572 614.04
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	293 284 261.00	363 755 261.23	(109 466 908.19)	547 572 614.04
Тайлант үеийн үр дүн	-	-	(3 928 414.11)	(3 928 414.11)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	293 284 261.00	363 755 261.23	(113 395 322.30)	543 644 199.93

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	529315900.00	496236406.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	529315900.00	496236406.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	529315900.00	496236406.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	354025700.00	354023306.29

210101	Үндсэн цалин	217494100.00	217491706.29
210102	Нэмэгдэл	109365400.00	109365400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2787100.00	2787100.00
210104	Урамшуулал	24379100.00	24379100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47793400.00	44253143.00
210201	Тэтгэврийн даатгал	33632500.00	30092243.00
210202	Тэтгэмжийн даатгал	3540200.00	3540200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2832200.00	2832200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	708000.00	708000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7080500.00	7080500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69440500.00	59319357.00
210301	Гэрэл, цахилгаан	3901800.00	3900911.00
210302	Түлш, халаалт	53076900.00	42956646.00
210303	Цэвэр, бохир ус	12461800.00	12461800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	654100.00	654100.00
210401	Бичиг хэрэг	140600.00	140600.00
210402	Тээвэр, шатахуун	61700.00	61700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	115 500.00	115 500.00
210404	Ном, хэвлэл	80 300.00	80 300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	256 000.00	256 000.00
2105	Нормативт зардал	50 865 900.00	31 466 200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3 254 300.0	3 254 300.0
210502	Хоол, хүнс	46 518 800.0	27 119 100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 092 800.0	1 092 800.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4 290 300.0	4 290 300.0
210604	Урсгал засвар	4 290 300.0	4 290 300.0
2107	Томилолт, зочны зардал	145 600.0	145 600.0
210702	Дотоод албан томилолт	145 600.0	145 600.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	575 600.0	559 600.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143 600.0	127 600.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432 000.0	432 000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1 524 800.0	1 524 800.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 524 800.0	1 524 800.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	529 315 900.0	496 236 406.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	455 585 100.0	432 626 749.3
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	455 585 100.0	432 626 749.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	73 730 800.0	63 609 657.0
132001	Орон нутгийн төсвөөс	73 730 800.0	63 609 657.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29.0	29.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18.0	18.0
620003	Үйлчлэх ажилтан	10.0	10.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29.0	29.0
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	19.0	19.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.0	10.0

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Тайлант онд нэмэлт дансаар орлого зардлын гүйлгээ хийгдээгүй болно.

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Жаргалант сумын 7 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг шууд захирагч Б. Төгсжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд нормативд зардал/хоол/, анхан шатны баримт /е баримт/ бүрдүүлэлт, цалингийн зардлын батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25 -наас 2021 оны 01 дүгээр сарын 31-ны хооронд Гэрэлт Хөхийн тэнцвэр аудит ХХК-ны Ховд аймаг дахь салбарын захирал аудитор Д.Хишгээ хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ:

2020-2021 оны хичээлийн жилд “Хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй орчин бүрдүүлж, өдөр тутмын хичээл хөгжүүлэх үйл ажиллагааг чанартай бэлтгэн үр дүнтэй зохион байгуулж хүүхдийн хөгжилд ахиц гарган багш ажилчид ёс зүй, харилцаа хандлагаар манлайлан, эцэг эх асран хамгаалагчдын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн хамтран ажиллана” гэсэн зорилго тавин ажилласан.

Үүнд:

- *Ээлжит хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааг хүүхэд бүрийн онцлогт тохируулан багаар хамтран бэлтгэж үр өгөөжтэй зохион байгуулах.*
- *Багш нарын заах арга ур чадварыг сайжруулах, багш ажилчид ажлын байрандаа хөгжих боломжийг бүрдүүлэн, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, туршлага солилцох, түгээн дэлгэрүүлэх олон нийтийн оролцоонд тулгуурлан хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй тоглонгоо хөгжих орчин бүрдүүлэх*
- *Төсвийн ил тод байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлэх*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай*
- *Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот “Хоолны зардлын норматив тогтоох тухай”*

3.3 Нягтлан БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Тус байгууллага санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2020 оны 12 дугаар сард Тус цэцэрлэгийн 2018-2019 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийсэн байна. Шалгалтаар нийт 1522.9 мянган төгрөгийн зөрчил төлбөр илэрснээс, 1405.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод, 117.9 мянган төгрөгийг нөхөн олгох акт тавигдсан байна.

Байгууллагын шилэн дансны мэдээллээр тус байгууллага батлагдсан төсөв болон санхүүгийн жилийн мэдээллийг самбараар мэдээлж байна.

Тухайн оны шилэн дансны мэдээллээ хугацаандаа оруулж улирал тутам тайлангаа илгээсэн тул зөрчил илрээгүй байна.

Сар бүр Жаргалант сумын төрийн сангийн мэргэжилтэн хяналт тавьж, гүйцэтгэлийг үнэлэхэд 99-100%-аар дүгнэгдсэн байна.

Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй батлагдсан Дотоод хяналтын баг, Өмч хамгаалах комисс ажилладаг бөгөөд сургалтын үйл ажиллагаа, өргөдөл гомдол, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг хариуцан хагас, бүтэн жилээр хөрөнгийн тооллого хийсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлого сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 314737.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3147.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3949.1 мянган төгрөгөөр буюу 0.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт
/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	41.5		41.5
Бараа материал	32 436.4	37 047.6	- 4 611.2
Үндсэн хөрөнгө	515 115.4	506 596.6	8 518.8
Нийт хөрөнгө	547 593.3	543 644.2	3 949.1
Өр төлбөр	20.7	-	20.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	547 572.6	543 644.2	3 928.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	547 593.3	543 644.2	3 949.1

Авлага дансны үлдэгдэл 0 мянган төгрөг болж оны эхний 41.5 мянган төгрөгөөр буурсан нь ндш-ын тооцооллын зөрүүгээр гарсан авлага юм. Тус байгууллагуудтай тооцоо нийлж өглөг авлагаа баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 37047.6 мянган төгрөг өмнөх оноос 4611.2 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар Тайваны гэр бүлийг дэмжих сангаас 1414.5 мянган төгрөгийн хөнжил гудас, углаа дэвсээ авч, тайлант онд 41331.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 38135.2 мянган төгрөгийн бараа материал зарлагдаж орлого, зарлагын зөрүүгээр өссөн байна.

Эм боох материалын үлдэгдэл 685.0 мянган төгрөгийн үлдэгдэл нь Жаргалант сумын Засаг даргын 2020-03-20-ны № 1/288 тоот албан бичиг/Жаргалант сумын ЕБС, СӨБ-ыг

гамшгаас хамгаалах аюулгүй байдлын нөөцийн жишиг жагсаалт/, 2020-03-13-ны өдрийн Жаргалант сумын онцгой комиссын хурлын шийдвэр № 05 шийдвэрээр эм боох материалын зардал дээр нөөц бэлтгэн ажилчдаа эм эмнэлгийн хэрэгсэл, нэг удаагийн ариутгалын иж бүрэн хувцас, маск, ариутгалын бодис, витамин зэргийг олгосон байна.

Оны эхэнд 2421.6 мянган төгрөгийн хүнсний үлдэгдэлтэй байснаа 26739,1 мянган төгрөгийн хүнс худалдан авч, 28370.8 мянган төгрөгийн хүнс зарцуулж оны эцэст 789,8 мянган төгрөгийн хүнсний үлдэгдэлтэй байна.

Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020-11-27-ны А/162 тоот тушаалыг үндэслэн Ховд аймгийн Жаргалант сумын 7 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн 2020-12-07-ны өдрийн тушаалаар тус цэцэрлэг хоол хүнс тэжээлийн дутагдалд өртөх эрсдэл бүхий өөрийн цэцэрлэгт хамрагддаг 13 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн орсон 40416,6 төгрөгийн нэг бүрийн үнэтэй 606,3 мянган төгрөгийн үнэ бүхий хоол хүнсийг 15 хүүхдэд олгосон байна.

Тайлант хугацаанд нийт 11476 хүүхэд өдөр ажиллаж 27764.5 мянган төгрөгний хоолны зардал гаргаж нэг хүүхдэд 2419.36 төгрөг зарцуулсан нь, нормоор зарцуулах ёстой норматив /2475/ төгрөгний зардлаас 55.64 төгрөгөөр дутуу олгогдож нийт 638.5 төгрөгний хоол дутуу өгсөн нь Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот “Хоолны зардлын норматив тогтоох тухай” тогтоолыг мөрдөж ажиллаагүй байна.

Бичиг хэрэг 80.0, аж ахуйн материал 395.0, бусад хангамжийн материал БҮТЭЗ 34682.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 612622,4 мянган төгрөг болж өмнөх оноос 20048,3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Барилга байгууламж дансанд 15999,3 мянган төгрөгөөр СӨБ-ын 7 дугаар цэцэрлэгийн барилгын дээврийн засварыг Жаргалант сумын ОНХСангийн хөрөнгө оруулалтаар Ховд баганат компаниар хийж гүйцэтгүүлэн хүлээн авч барилга дансыг капиталжуулан нэмэгдүүлсэн байна.

Машин тоног төхөөрөмж данс дансны үлдэгдэл 53864.2 мянган төгрөг болж өмнөх оноос 4049.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 550.0 мянган төгрөгөөр цаг бүртгэлийн машин худалдан авч, БСУГ-аас 2 ш нөөтбүүк хөрөнгө оруулалтаар, ирснээс шалтгаалжээ

Тавилга данс 40614.3, номын фонд 1721.8, программ хангамж 200.0, бусад биет бус хөрөнгө 49039.2 мянган төгрөгний үлдэгдэлтэй байгаа бөгөөд өмнөх оноос ямар нэгэн өөрчлөлт гараагүй байна.

Үндсэн хөрөнгө дансны хуримтлагдсан элэгдэл оны эхэнд 77458.6 мянган төгрөг байснаас тайлант онд 28567.1 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгийн дансанд ямар нэгэн өөрчлөлт гараагүй байна. Тус байгууллага өр төлбөр дансны үлдэгдэлгүй .

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 543644.2 мянган төгрөг болж өмнөх оноос /-3928,4/ мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн байна.

2020-ны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 80560.7 мянган төгрөгөөр буюу 17 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 80560,7 мянган төгрөгийн орлого нь өмнөх оноос тусгай зориулалтын болон орон нутгийн санхүүгийн дэмжлэг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫНДҮН	469 668.0	550 228.7	(80 560.7)

Нийт зардал өмнөх оноос 67580,2 мянган төгрөгөөр буюу 14 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 76208,2, нийгмийн даатгалын шимтгэл 10120,0, бараа үйлчилгээний бусад зардал 380,2 мянган төгрөгөөр тус тус өсөж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд 11677,2, хангамж бараа материалын зардал 180,3, нормативт зардал 32290,0, эд хогшил урсгал засварын зардал 3041,3, бараа үйлчилгээний бусад зардал 5009,8 мянган төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Энэ нь өмнөх оноос цалин хөлсний зардалд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл шинээр тооцогдон олгогдсон, төсвийн хэмнэлтээс 33079,5 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	486 577.0	554 157.1	- 67 580.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	486 577.0	521 077.6	- 34 500.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	276 856.6	353 064.8	- 76 208.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35 112.4	45 232.4	- 10 120.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66 165.6	54 488.4	11 677.2
Хангамж, бараа материалын зардал	843.5	663.2	180.3
Нормативт зардал	65 392.8	33 093.8	32 299.0
Эд хогшил, урсгал засварын зардал	7 240.8	4 199.5	3 041.3
Томилолт, зочны зардал	145.6	145.6	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	195.8	576.0	- 380.2
Бараа үйлчилгээний бусад зардал	34 623.8	29 613.9	5 009.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	33 079.5	- 33 079.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(16 909.0)	(3 928.4)	- 12 980.5
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(16 909.0)	(3 928.4)	- 12 980.5

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан ямар нэгэн өөрчлөлт байхгүй.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 586689,6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 586689.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төсөлд 2020 онд хасах тодотгол хийж 57373.7 мянган төгрөгөөр бууруулж 529315.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасан Коронавируст халдвар/ковид-19/ цар тахалтай холбоотой анх батлагдсан төсвөөс хасаж тодотгол хийсэн 57373.7, оны сүүлчээр зарцуулаагүй үлдэгдэл санхүүгийн дэмжлэгээ буцаан төвлөрүүлсэн 33079.5 бүгд 90453.2 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг зарцуулаагүй байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 529315.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 455585.1 мянган төгрөгийг тусгай зориулалтын санхүүгийн дэмжлэгээр, 73730.8 мянган төгрөгийг орон нутгийн санхүүгийн дэмжлэгээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр 432626,7, орон нутгийн санхүүгийн дэмжлэгээр 63609,7 бүгд 496236,4 мянган төгрөгийн санхүүжилт авч,

урсгал үйл ажиллагаанд 49636.4 мянган төгрөгийг зарцуулж 33079.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 496236.4 мянган төгрөг буюу 93.75 хувьтай буюу 33079,5 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

- ✚ Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 2.3 мянган төгрөгөөр хэмнэсэн нь тухайн онд ковид-19 буюу цар тахалтай холбоотой цэцэрлэгийн үйл ажиллагаа хэдэн сараар хүүхэд авахгүй хойшилсноос шалтгаалжээ.
- ✚ Нийгмийн даатгалын шимтгэл: 3540.2 мянган төгрөгөөр хэмнэсэн нь анх төсөв төлөвлөхдөө нэг хувийн илүү тооцоололт хийгдсэн тул тухайн санд үлдээн буцаан төвлөрүүлсэн байна.
- ✚ Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 10121.1 мянган төгрөгийг хэмнэсэн нь дулаан халаалтыг нэг сарын өмнө зогсоосон, Шим ус ХХК-тай ковид -19 цар тахалтай гарсан учраас гэрээнд өөрчлөлт оруулж хоёр сарын төлбөрийг хагас төлбөрөөр төлснөөс шалтгаалсан байна.
- ✚ Нормативт зардал 19399.7 мянган төгрөгөөр хэмнэсэн нь Ковид-19 буюу цар тахалтай холбоотойгоор цэцэрлэгийн үйл ажиллагаа зарим сард ажиллаагүй, зарим сард хагас ажилласан, зуны улиралд ээлжийн бүлэг ажиллаагүйтэй холбоотой ,

Тус байгууллагын 2019 онд авч байсан цалинг 2020 онд авч байсан цалинтай харьцуулан авч үзвэл өмнөх оноос 29508.3 мянган төгрөгөөр цалингийн зардал өссөн байна.

Үзүүлэлтүүд	2019 ОН	2020 ОН	зөрүү	хувь
Үндсэн цалин	172 721.9	202 230.2	29 508.3	38,7
орон нутгийн нэмэгдэл	9 964.3	11 562.1	1 597.8	9,3
Заах аргын нэгдэл	354.4	1 837.7	1 483.3	8,6
Зэргийн нэмэгдэл	6 670.9	8 067.3	1 396.4	8,1
Илүү цаг	20 652.6	18 382.1	- 2 270.5	- 13,2
Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл		25 688.7	25 688.7	33,7
Ур чадвар	7 538.1	9 340.9	1 802.8	10,5
Үр дүн	22 739.1	20 897.4	- 1 841.7	- 10,7
Унаа хоол		9 200.0	9 200.0	53,5
Бусад		314.5	314.5	1,8
Амралт	36 215.3	45 543.8	9 328.5	54,3
Нийт дүн	276 856.6	353 064.7	17 191.5	100,0

Хүснэгтээс харвал илүү цагийн хөлс 2270.5, үр дүнгийн нэмэгдэл 1841.7 мянган төгрөгөөр тус тус буурч үндсэн цалин 29508.3, орон нутгийн нэмэгдэл 1597.8, заах аргын нэмэгдэл 1483.3, зэргийн нэмэгдэл 1396.4, Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 25688,7, ур чадвар 1802,8, Унаа хоол 9200,0, бусад нэмэгдэл 314,5, амралт 9328,5 мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ. Үүнээс : Шинээр төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлд нийт зөрүүний өсөлтийн 33,7 хувь буюу 25688,7 мянган төгрөг байна.

Оны эцэст Коронавируст халдвар ковид-19 цар тахалтай холбоотой үйл ажиллагаа тасалдсанаас батлагдсан төсөвт зардал хэмнэсэнтэй холбоотой өмнөх оноос өссөн цалингийн өсөлтийн 53,5 хувь буюу 9200,0 мянган төгрөгийг унаа хоолны хөнгөлөлтөнд олгосон байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээ 496236,4 мянган төгрөгөөр, 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээ 33079,4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд тус байгууллагын нэмэлт дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 151 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар МУЗГ-ын 2012 оны 10-27-ны №106 тоот тогтоолоор батлагдсан хоолны нормативаас дутуу зарцуулж байсанд дүгнэлт хийж ажиллах зөвлөмж өгөгдсөн боловч биелүүлээгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 40130,8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 33079,4 мянган төгрөгний алдааг залруулж, 7051,4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Алдааны дүн материаллаг бус цар тахалын үед ажилчидадаа олгосон нэмэгдэл хөлс нь олон хүнийг хамруулсан учраас 6412,9 мянган төгрөгийг алдааны дүнд оруулаагүй болно.

Залруулсан алдаа: Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай /үр дүнгийн тайлангийн 33079,4 мянган төгрөг/ залруулга хийгдлээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил: Аудитаар залруулагдаагүй алдаа, зөрчил байхгүй.

Аудитын зөвлөмж : Аудитаар илэрсэн 638,5 мянган төгрөгний алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараах 2 асуудлыг аймгийн ТЕЗ-ын нэгтгэсэн тайлангийн үеэр анхаарал хандуулж дахин хянаж хэрэгжилтийг нэгтгэн хянах шаардлагатай байна. Үүнд:

- 2020-09-03-ны өдрийн А/483 тоот Ховд аймгийн Засаг даргын захирамжаар Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдийн анги танхим байрны дотоод орчны агаарын чанарыг сайжруулан дэвшилтэт технологи болох “Окфил”агаар шүүгчийг суулгах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн байна. Тус цэцэрлэгт 40 ширхгийг 8 ангид 4520.0 мянган төгрөгөөр нийлүүлсэн,
- 2020 оны 02 сарын 18-ны Ховд аймгийн Засаг даргын А/107 тоот захирамжаар “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хөрөнгө гаргах тухай захирамжаар Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмнэлтээс 380.0 мянган төгрөгийн маск нийлүүлэх гэрээ хийж Буянт үйлийн шим ХХК-д шилжүүлсэн
- БСУГ-аас хөрөнгө оруулалтаар Dell latitude 3400 CTO Business model 2 ширхэг нөтөбүүкийг нэг бүрийг 1749500 төгрөгөөр 3499,0 төгрөгөөр бэлтгэсэн зэрэг асуудлуудыг аймгийн ТЕЗ-ын нэгтгэсэн тайлангаар авч үзэх шаардлагатай байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Зардлын данстай холбоотой асуудал.

Нормативт зардал /Хоол /

Илрүүлэлт: Тайлант онд нийт 11476 хүүхэд өдөрт 27764,5 мянган төгрөгний хоолонд зарцуулж нэг хүүхдэд 2419,36 төгрөг ноогдож, норматив /2475/ зардлаас 55,64 төгрөгөөр дутуу зарцуулж нийт 638,5 мянган төгрөгний хоол дутуу олгосон байна Үнэлгээ, Хэмжилт, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна МУЗГ-ын тогтоол зөрчсөн байна.

- 1.1. *Эрсдэл:* хууль, дүрэм, журам зөрчигдөх
- 1.2. **Өгсөн зөвлөмж:** Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот “Хоолны зардлын норматив тогтоох тухай” тогтоолыг мөрдөх
- 1.3. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвшөөрч байна.

И-баримтын бүрдүүлэлт

2.1. *Илрүүлэлт:* Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу байна. Иж бүрэн, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ-ийн тухай хууль зөрчсөн байна.

2.2. *Эрсдэл:* тайлан буруу илэрхийлэгдэх, хуурамч зарлага гаргах

2.3. **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллах

2.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвшөөрсөн

Цалингийн зардал

3.1. *Илрүүлэлт:* Оны эцэст Коронавируст халдвар ковид-19 цар тахалтай холбоотой үйл ажиллагаа тасалдсанаас батлагдсан төсөвт зардал хэмнэсэнтэй холбоотой өмнөх оноос өссөн цалингийн өсөлтийн 53,5 хувь буюу 9200,0 мянган төгрөгийг унаа хоолны хөнгөлөлтөд олгосон байна. Батлагдсан төсөв /9200,0- 2787,1/ хасаад 6413,0 төгрөг Иж

бүрэн, Үнэлгээ, Хэмжилт, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй бөгөөд Төсвийн тухай хууль зөрчсөн байна.

3.2. *Эрсдэл:* төсвийн хөрөнгийг буруу зарцуулах, эдийн засгийн ангилал зөрчих, төсвийн төлөвлөлт буруу төлөвлөх

3.3. *Өгсөн зөвлөмж:* Төсвийн тухай хуулийн 4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчмыг баримтлан ажиллах

3.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Жаргалант сумын 7 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ХОА-2021/11/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	Жаргалант сумын 7 дугаар цэцэрлэг		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үр дүнгийн тайланд орлого дутуу тайлагнасан	33079,4	Залруулга		
2	Хүүхдийн хоолны норм дутуу зарцуулсан	638.5	Зөвлөмж		
3	Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу		Зөвлөмж		
	Батлагдсан төсөвт зардал хэмнэсэнтэй холбоотой 6412,9 мянган төгрөгийг унаа хоолны хөнгөлөлтийг нэр бүхий 26 албан хаагчдад олгосон байна.	6412,9	Зөвлөмж		
ДҮН		40130.8			

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

Огноо:2021. 02.02

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

Огноо:2021.02.02

БЭЛТГЭСЭН:

ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ ХХК-НЫ ХОВД АЙМАГ ДАХЬ

САЛБАРЫН ЗАХИРАЛ, АУДИТОР

Д.ХИШГЭЭ

Огноо:2021. 02.02